

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР



ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Дулааны үйлвэрлэлийн үндсэн ба туслах тоноглолыг инженерийн дулааны шугам, цэвэр ус түгээх бохир усны цугуулах, татан зайлуулах сүлжээний шугамд шинэчлэн сайжруулахгүй бол үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний өртөг нэмэгдэх, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангаж дийлэхгүй, цэвэр ус, бохир ус үнэ тарифыг нэмэгдүүлээгүйгээс суурь шалтгаан болж Үйлдвэрийн газрын алдагдлыг нэмэгдүүлж байна.

АУДИТЫН СЭДЭВ: ТУУЛЫН ХИШИГ" ОНӨААТҮГ-ЫН
2024, 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ДА-2025/03/ҮА-ОНА

СҮХБААТАР СУМ
2025 ОН

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ДОТООД АУДИТОР: Д.ВАНЧИГМАА

ХОЛБОО БАРИХ УТАС: 7036-8811

ЦАХИМ ХАЯГ: VANCHIGMAA@SANKHUUAUDIT.SE.GOV.MN

УТӨТАС: 7036-8811

ЭНЭХҮҮ ДОТООД АУДИТЫН ТАИЛАНТАЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙГ ДЭЭРХ ХАЯГААР АВНА УУ.

Товчилсон үгийн жагсаалт

ДАМПОУС	<i>Дотоод Аудитын Мэргэжлийн Практикийн Олон Улсын Стандарт</i>
ААНБ	<i>Аж ахуй нэгж байгууллага</i>
ИТХ	<i>Иргэдийн төлөөлөгчдийн хурал</i>
НДШ	<i>Нийгмийн даатгалын шимтгэл</i>
НББТХ	<i>Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль</i>
НӨАТ	<i>Нэмэгдсэн өртгийн албан татвар</i>
ОНӨААТҮГ	<i>Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар</i>
ХХК	<i>Хязгаарлагдмал хариуцлагатай компани</i>
ХХОАТ	<i>Хувь хүний орлогын албан татвар</i>
ЭХЗХ	<i>Эрчим хүчний зохицуулах хороо</i>
ТБОНӨТХ	<i>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль</i>
ГХБХБГ	<i>Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар</i>
УБХ	<i>Улсын бүртгэлийн хэлтэс</i>

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:</p>	<p>Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, "Дүрэм батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм", Дотоод аудитын хорооны 2025 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын зорилт:</p>	<p>"Туулын Хишиг ОНӨААТҮГ"-ын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.</p>
<p>Аудитын хамарсан хүрээ:</p>	<p>Тус газрын 2024он-2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн баримт материалыг хамруулав.</p>
<p>Аудитын арга зүй:</p>	<p>Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон улсын стандарт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм", Монгол улсын сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар батлагдсан "Улсын салбарын дотоод аудитын аргачлал"-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулалт, түүвэрлэлт зэрэг судалгааны арга зүйг ашиглан аудитын дүнд суурилан дүгнэлт өгч, зөвлөмж боловсрууллаа.</p>
<p>Аудитын шалгуур, үзүүлэлт :</p>	<p>Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн хэмнэлтийн тухай хууль • Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль • Татварын ерөнхий хууль • ТБОНӨХБАҮХАТ • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль • Хөдөлмөрийн тухай хууль, • Нийгмийн даатгалын тухай хууль • Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль • Хувь хүний орлогын албан татварын тухай хууль • Хот,суурин ус хангамж,ариутгах татуургын татуургын ашиглалтын тухай хууль • Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 2 дүгээр хавсралтаар баталсан "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм • Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтын шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" • Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 2 дүгээр хавсралтаар баталсан "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм • Сэлэнгэ аймгийн Эрчим хүчний Зөвлөл 2022 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан "Тариф батлах тухай" • 2022 оны Сэлэнгэ аймгийн Эрчим хүчний Зөвлөл 17 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф" <p>"Туулын Хишиг" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэм</p> <ul style="list-style-type: none"> • Сумын Засаг даргатай байгуулсан 2024он2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө • "Туулын Хишиг" -ын хүний нөөцийн бодлогын баримт бичиг • Байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг • Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Байгууллагын засаглалын тогтолцоо

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 04 дугаар сарын 08-ний өдрийн 51 дүгээр тогтоолоор "Туулын Хишиг" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулагдсан.

"Орхонтуул суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, айл өрхийг дулааны эрчим, түгээх, хэрэглээний улмаас гарсан бохир усыг татан зайлуулах ажлыг байнгын хэвийн найдвартай хангаж, эдийн засгийн алдагдлыг бууруулна" гэсэн зорилготойгоор дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Туулын Хишиг ОНӨААТҮГ-ын дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаараа

- Орхонтуул сумын төсвийн байгууллагуудын дулаан хангамж, тохижилт орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг харилцан гүйцэтгэх, хяналт тавих
- Сумын төв хөдөөд газар тариалан эрхлэх, дулаан хангах, цэвэр усаар хангах айл өрх, аж ахуйн нэгж байгууллагатай хангах, хэрэглэх гэрээ хийх, ашиглалтын төлбөр тооцоо хийх
- Орон нутгийн өмчийн техник бусад хэрэгслээр төсвийн байгууллагад захиалгат үйлчилгээг мөн тогтоосон үнэ тарифаар үйлчилгээ үзүүлэх

Гүйцэтгэх удирдлагын менежментийг сайжруулахад удирдлагаас шалтгаалах байгууллагын үйл ажиллагааны эдийн засгийн тооцоог үр дүнтэй оновчтой ашигт ажиллагааг дээшлүүлэхэд шаардлагатай шийдвэрийн төслийг боловсруулан сумын ИТХ-аар хагас бүтэн жилээр хэлэлцүүлж байх нь зүйтэй юм.

1.2 Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны эрсдэлийг үнэн зөв тодорхойлон үр нөлөөг үнэлж дүгнэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн эсэх

. Байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвшлийг тодорхойлоход эрсдэлийн соёл, эрсдэлийн засаглал, эрсдэлийн үйл явц эхлэлийн буюу 1-р түвшинд байна. Иймд "Туулын Хишиг" ААТҮГ-ын даргад байгууллагын уламжлалт болон урьдчилан тооцоолсон эрсдэлийг бүртгэж түүнийг бууруулах, урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцох чиглэлээр арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг өгч байна.

1.3 Байгууллагын дотоод хяналтын тогтолцоо

Туулын Хишиг нь дотоод хяналтыг зохион байгуулах журмыг боловсруулан байгууллагын даргын 2023 оны А/36 дугаар тушаалаар батлуулсан байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг 1.4 дэх заалттай нийцээгүй бөгөөд тус журмын дагуу гүйцэтгэх дотоод хяналтыг 4 зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг

тайлагнах үйл явц хангалтгүй байна.

Цаашид гүйцэтгэх удирдлагын зүгээс чиг үүргийн хэрэгжилтийг хангахдаа эрсдэл, хяналтын тогтолцоог төлөвшүүлэх замаар дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

ХОЁР. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Орхонтуул сумын Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт, үр дүн

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11дүгээр зүйлийн 3,20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу "Туулын хишиг ОНӨААТҮГ-ын даргатай гэрээ байгуулж 2024-2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин хөрөнгө орлуулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 315,060.9 мянган төгрөгөөр, нийт зардлыг 426,345.0 мянган төгрөгөөр алдагдлыг 111,284.1 мянган төгрөгөөр тооцож баталсан 1арга хэмжээнд 3520,0 мянган төгрөг төлөвлөсөн.

Тайлант 2024 оны гүйцэтгэлээр борлуулалтын орлого 317,783.8 мянган төгрөгийн, сумын ЗДНХ-өөс 15,000 мянган төгрөгийн дэмжлэг төвлөрүүлж нийт зардал 423,798.4 мянган төгрөгийн, 91,014.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. нийт орлогыг төлөвлөгөөг 100,9 хувь 2,722.9 мянган төгрөгөөр давуулан биеүүлсэн байна. Нийт зардлыг гүйцэтгэл 2,546.0 мянган төгрөгөөр 0,6 хувь хэмнэж гэрээний хэрэгжилтийн хангасан байна

2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин хөрөнгө орлуулалтын төлөвлөгөөг нийт орлогыг 155,055.3 мянган төгрөг, нийт зардлыг 255,982 мянган төгрөгийн, алдагдлыг 100,927.0 мянган төгрөгийн тооцож баталсан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт борлуулалтын орлого 177,088.0 мянган төгрөг, нийт зардал 247,153.0 мянган төгрөг (70,065.0) төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Боруулалтын орлогын төлөвлөгөөг 114, хувь 22,033.0 мянган төгрөгөөр давуулан биеүүлсэн байна. Нийт зардлыг 8,829.0 мянган төгрөгөөр 0,4 хувь хэмнэлтэй тайлгасан байна.

2.2 Эрчим хүчний зохицуулах хорооны баталсан тарифын хэрэгжилтийн, үр нөлөө

Тус газар нь ЭХЗХ-ны 2022 оны 08 дүгээр сарын 15-ний өдрийн 17 дугаар тогтоолоор үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт 1,470.02 төгрөг/м³, төг/Гкал 86560 төгрөг орон сууцны халаалт, ахуйн хэрэглээний халуун ус халаасан төгрөг/м², төгрөг /хүн500, тарифыг баталсныг мөрдөж байна.

2022-2024 онууд шатахуун, тосол материалын үнэ 20-30%, цахилгааны үнэ 42% нүүрсний үнэ 62% хувиар нэмэгдсэн байгууллагын эдийн засагт сөргөөр нөлөөлөж дулаан үйлдвэрлэлийн тариф батлагдсан өртөгөөс зардал хэтэрсэн нь 2024 онд (91,014.6) мянган төгрөгийн алдагдалтай ажилласан 2025 он эхний хагас жилийн байдлаар (70,813.7) мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж байна.

Цэвэр ус үнэ үнэ тарифыг 2010 онд батлагдсан тогтоолыг мөрдөж байна. Усны борлуулалтын орлого зардлаа өртгөө нөхөж чадахгүй алдагдалтай байна

2.3 Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт

ОНӨГ-ын барилга үндсэн хөрөнгөнд 38,946,5 мянган төгрөгийн, дулаан цэвэр, бохир

шугам 216,776.9 мянган төгрөгийн ,тоног төхөөрөмж 468,422.3 мянган төгрөг ,тээврийн хэрэгсэл 135,350.0 мянган төгрөгийн , тавилга, эд хогшил 1,063.9 мянган төгрөгийн компьютер 8,043.0 мянган төгрөгийн, газар 1,484,469.6 мянган төгрөгийн дансанд бүртгэлтэй байна. Дулааны шугамын сүлжээний хоолой, бохир усны шугам сүлжээний , хоолой цэвэр усны сүлжээний хоолой трубаны голч хэмжээ зузаан нимгэн дм ,мм, хэмжээ ашиглалт орсон хугацаа тодорхой биш бүртгэсэн байна.Бохирын шугам хоолой холбогдсон бохир худаг, дулааны шугам сүлжээнд цэвэр усны сүлжээнд холбогдсон цэвэр ус худаг худаг байршил тодорхойгүй бүртгэсэн

Туулын Хишиг ОНӨААТҮГ үндсэн хөрөнгийн ангилалд бүртгэлтэй ашиглах боломжгүй, 260,651.0 мянган төгрөгийн 4 төрлийн хөрөнгө элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган аймгийн ОНӨГ-т хандаагүй.

2.4 “Туулын Хишиг” ОНӨААТҮГ-ын орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдал

- *Тус үйлдвэрийн газрын аудитад хамрагдсан 2024-2025 онуудад дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагаа дулаан алдагдал бууруулж сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний ажиллагаанд дараах эерэг өөрчлөлт гарсан байна. Үүнд:
Аж ахуйн нэгж байгууллага ,айл өрх дулаан хэрэглэгчид барилгын дулааны алдагдлын бууруулахад албан шаардлага өгөөч хийж хяналт тавьж ажилласан*
- *Дулааны шугам сүлжээ ,эхний худгаас төгсгөлийн худаг хүртэл , цэвэр усны шугам хоолой, бохир усны шугам хоолой худагт хэсгүүдийн завсар үйлчилгээ ажлыг хийсэн*
- *Дээрх ажлыг үр дүнд өвлийн их ачлалтай улиралд дулааны шугам хоолойн цэвэр усны шугам ,бохир усны хөлдөлтийн гэмтлийн дуудлага урьд өмнөх оноос бага шугам усны нэмэгдлийг зарцуулалт бууруулсан*
- *Үйлдвэрлэлийн хүчин чадалыг өргөжүүлэх, сүлжээг шинэчлэх, эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх болон зохион байгуулалтыг сайжруулах ажил хэрэгжүүлээгүй байна*

2.5 Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын талаар.

Сэлэнгэ аймаг Орхонтуул сумын Иргэдийн төлөөлөлчдийн Хурлын 2024оны 11-р сарын 06 өдрийн 12дугаар тогтоолоор Туулын Хишиг ОНӨААТҮГ-ын ажилчдын цалин 2025 оны 1 дүгээр сарын 1ны өдрөөс 50% цалин нэмэгдсэн байна

Тус үйлдвэрийн газрын орон тооны дээд хязгаарыг 2024 онд 15 албан хаагч орон тоотой тооцож цалингийн сангийн зардлыг 2025 онд өмнөх оноос 50% хувь буюу нийт цалингийн 179,218.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Цалингийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэлийг дараах хүснэгтэд харуулав.

Д/д	Тайлант он	Төлөвлөгөө			Гүйцэтгэл			Зөрүү	
		Нэг ажилтны дундаж цалин	Орон тоо	Цалингийн сан	Нэг ажилтны дундаж цалин	Орон тоо	Цалингийн сан	Хэтрэлт/ хэмнэлт	Хувь
1	2024	774,3	14	125,055.0	737,9	14	123,976.0	1079	99.8
2	2025	1,066.7	14	89,608.0	1,265.5	14	106,305.0	16,697.0	118,6
Дүн		548.0			516.8			31,2	89.8
Дүнд эзлэх хувь		170,7	-	135.6	170.0	-	132.2		

Дээрх хүснэгтээс харахад 2024 онд орон тооны хангалт 99.8 хувьтай 2024 онд 96,1 хувьтай цалингийн зардлыг гүйцэтгэлийн өмнөх онтой харьцуулахад 55,243.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь

тайлант онд албан хаагчдын цалинг 50 хувиар нэмэгдүүлэхээр баталснаас бодит гүйцэтгэлээр хувиар нэмэгдүүлсэн боловч нэг ажилтанд оногдох дундаж цалин хөлсийг 2025 онд төлөвлөснөөс 31,2 мянган төгрөгөөр хэтрүүлж 1,265.5 мянган төгрөг болгосон нь өмнөх оны нэг ажилтанд оногдох дундаж цалин хөлсийг 516.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна

Сумын Засаг даргаар батлуулсан тус үйлдвэрийн газрын санхүүгийн төлөвлөгөөгөөр батлагдсан цалингийн сангийн гүйцэтгэл 2024 онд үндсэн цалинг өмнөх оноос 50 хувиар, нэмэгдэл цалинг нэмэгдүүлсэн нь байна

2.6 Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилт

Туулын Хишиг" ОНӨААТҮГ Сумын онцгой комиссын шийдвэрээр Засаг даргын нөөцөөс 15,000. 0 мянган төгрөг гаргуулан дулааны шугамын засвар хийсэн

Сумын төвийн инженерийн шугамын бохир ус татан зайлуулах шугам сүлжээнд сүүлийн жилүүдэд их засварын ажлыг хийгээгүйгээс шугам гэмтэл ихтэйгээс мөн цэвэрлэх байгууламжгүйгээс шалтгаалан хаягдал бохир усны лаг, суурин газар суурьшлын бүсэд ил задгай урсаж байгаа нь хүн амын амьдрах орчин, эрүүл мэнд, байгаль орчинд хөрсний бохирдуулж аюултай эрсдэл ихтэй нөхцөл байдал үүссэн байна. Инженерийн шугам бохир ус татан зайлуулах шугам сүлжээ 20 бохир усны худагтай холбогдсон байгууламж 1974 онд ашиглалтад орсон бөгөөд 51 дахь жилдээ хуучирч муудсан ашиглалтын насжилтын хугацааны дууссан шугамыг ашиглан ажиллаж байгаа үйлдвэрлэлийн ажиллагаанд сөрөг нөлөөлж байна. Иймд бохир цэвэрлэх барилга байгууламж болох, инженерийн бохир усны шугамын техник тоноглолыг шинэчлэлт хийх нэн даруй шаардлагатай байгаа тул сумын удирдлагууд болон иргэд төлөөлөгчдын хурлаар танилцуулж сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний, инженерийн дэд бүтцийн төлөвлөгөөнд оруулж бохир цэвэрлэх барилга байгууламжийн зураг төсөв, боловсруулж инженерийн бохир усны шугамын техник тоноглолыг шинэчлэлтийг тусган төлөвлөж, шаардлагатай санхүүжилтийг улс болон орон нутгийн төсөвт суулгаж хэрэгжүүлэх шийдвэр гаргах нь нийгэмдээ ач холбогдолтой зүйтэй гэж байна.

2.7 Санхүүгийн үйл ажиллагаа

Тус үйлдвэрийн газрын нийт хөрөнгө 2024 онд өмнөх оноос 55,251.1 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсантай холбоотой байна.

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Хүснэгт 2

/мянган төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,545.7	634,5	(911,2)
Авлага	73,526.2	75,045.8	1,519.6
Бараа материал	6,518.1	8,662.9	2,144.8
Үндсэн хөрөнгө	475,167.5	417,163.2	(58,004.3)
Биет бус хөрөнгө	1,484,696.0	1,484,696.0	
Нийт хөрөнгийн дүн	2,041,453.5	1,986,202.4	(55,251.1)
Богино хугацаат өр төлбөр	126,704.4	142,467.9	15,763.5
Эздийн өмч	2,118,488.0	2,118,488.0	
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	164,604.3	164,604.3	
Хуримлагдсан ашиг/алдагдал	-368,343.2	-439,357.8	71,014.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,041,453.5	1,986,202.4	55,251.1

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- ✓ Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 911,2 мянган буурсан нь үйл ажиллагааны зардалтай холбоотой байгаа 360,914.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 361,825.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- ✓ Авлага дансны үлдэгдэл 75,045.8 мянган төгрөг болж 1,519.6 мянган төгрөгөөр өссөн нь дулааны авлага 3,165.9 мянган төгрөгөөр, ажилчдаас авах авлага 362.4 мянган төгрөг зэрэг нийт 3,528,0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 2,008.7 мянган төгрөгийн авлага барагдуулснаас холбоотой байна. Сэлэнгэ аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2016 оны 07 сарын 08-ний өдрийн 26 тоот тогтоолоор дулаан эрчим хүчний тарифт үнийг үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт 1,176.02 төгрөг/м³ батлагдсан дагуу 2017 оны 01-р сарын 1-ний өдрөөс мөрдсөн боловч ерөнхий боловсролын дунд сургууль 30,887.4 мянган төгрөг, цэцэрлэг 1,345.6 мянган төгрөг, Соёлын төв 4,538.3 мянган төгрөгийн, эдгээр байгууллагуудын халаалтын санхүүжилт хүрэлцэхгүй 2017-2018 онуудын нийт 36,771.3 мянган төгрөгийн авлага үүссэн байна. Айл өрх дулааны авлага 9,3 хувь, аж ахуйн нэгж байгууллага авлага 4,7 хувь төсөвт байгууллага авлага 49 хувь дансны авлага 37 хувь эзэлж байна
- ✓ Бараа материал дансны үлдэгдэл 8,662.9 мянган төгрөг болж 2,144.8 мянган төгрөгөөр өссөн нь 136,984,2 мянган төгрөгийн бараа материал орлогот авсан

болон сумын ЗДНХ-өөс 15,000.мянган төгрөгийн дэмжлэгийг авч дулааны шугамын засварын материал авсан үйл ажиллагаандаа 149,839.4 мянган төгрөгийн бараа материал түүхий эдийг зарцуулсан шалтгаалсан байна .

- ✓ Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 865,083.1 мянган төгрөг болж 3,520.5мянган төгрөгөөр өссөн нь өөрийн хөрөнгөөр компьютер худалдан авсантай холбоотой .Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 451,439.9 мянган төгрөг бөгөөд 417,163.3 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна
- ✓ Өр төлбөр дансны үлдэгдэл 142,467.9 мянган төгрөг болж 15,763.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд цахилгааны зардал өглөг 60,297.6мянган төгрөгийн цалингийн өглөг 123,976.5 мянган төгрөг ,татвар шитгэлийг 71,210.0 мянган төгрөгөөр,бараа үйлчилгээний зардлыг өглөг 168,032,5 мянган төгрөг зэрэг нийт 423,516.6 мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүсч 407,753.3 мянган төгрөгийн өр барагдуулсан байна.Өр төлбөрийн 36,8 хувийг бараа үйлчилгээний 37,5хувийг татварын өр төлбөр,25.7хувийг насжилт өндөртэй дансны өр төлбөр эзэлж байна

Тус үйлдвэрийн газрын нийт хөрөнгө 2025 онд өмнөх оноос 23,032.1мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсантай холбоотой байна.

Хүснэгт 3

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	634.5	1226.4	-591.9
Авлага	75,045.7	72194.3	2,851.4
Бараа материал	8,662.9	3516.7	5,146.2
Үндсэн хөрөнгө	417,163.2	401536.8	15,626.4
Биет бус хөрөнгө	1,484,696.0	1484696.0	0.0
Нийт хөрөнгийн дүн	1,986,202.3	1963170.2	23,032.1
Богино хугацаат өр төлбөр	142,467.9	189500.5	-47,032.6
Эздийн өмч	2,118,488.0	2118488.0	0.0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	164,604.3	164604.3	0.0
Хуримлагдсан ашиг/алдагдал	-439,357.9	-509422.6	70,064.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,986,202.3	1963170.2	23,032.1

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 591,9 мянган буурсан нь үйл ажилагааны зардалтай холбоотой байгаа 360,914.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 361,825.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Авлага дансны үлдэгдэл 75,045.8 мянган төгрөг болж 1,519.6 мянган төгрөгөөр өссөн нь дулааны авлага 3,165.9 мянган төгрөгөөр,ажилчдаас авах авлага 362.4мянган төгрөг зэрэг нийт 3,528,0 мянган төгрөгөөр нэмэгдэж,2,008.7мянган төгрөгийн авлага барагдуулснаас холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 8,662.9 мянган төгрөг болж 5.146.2 мянган төгрөгөөр өссөн нь 62,635,4мянган төгрөгийн бараа материал орлогот авсан 67,781.5

мянган төгрөгийн бараа материал түүхий эдийг зарцуулсан шалтгаалсан байна .

- ✓ Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 865,083.1 мянган төгрөг болж .Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 463,546.9 мянган төгрөг бөгөөд 401,536.8 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна
- ✓ Өр төлбөр дансны үлдэгдэл 189,500.5 мянган төгрөг болж 47,032.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд цахилгааны зардал өглөг 35,282.4мянган төгрөгийн цалингийн өглөг 100,971.8 мянган төгрөг ,татвар шитгэлийг 71,259.0 мянган төгрөгөөр,бараа үйлчилгээний зардлыг өглөг 52,600.8 мянган төгрөг зэрэг нийт 260,114.0 мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүсч 213,081.6 мянган төгрөгийн өр барагдуулсан байна.Өр төлбөрийн 28,1 хувийг бараа үйлчилгээний 34,3хувийг татварын өр төлбөр,37.6хувийг насжилт өндөртэй дансны өр төлбөр эзэлж байна

2.8 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшний төлөвлөлт

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 болон 20 дугаар зүйлийн 20.3-д заасны дагуу "Туулын Хишиг" ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, Сумын Засаг даргаар батлуулж, гүйцэтгэлийг тайлагнаж ажилласан байна.

Хүснэгт 4

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Төлөвлөгөө		Зөрүү	Хувь
			2024	2025		
1	Борлуулалтын орлого	м/төг	315,060.9	310,100.0	4,960.0	85%
2	Бусад орлого	м/төг				
3	Орон нутгийн татаас	м/төг			-	
2	Нийт орлого	м/төг	315,060.9	310,100	4,960.9	85%
3	Нийт зардал	м/төг	426,345.0	511,964.1	85,618.1	120%
	Үүнээс: Удирдлагын зардал	м/төг	60,515.5	60,515.5		100%
4	Татварын өмнөх ашиг	м/төг	(111,284.1)	(201,864.1)	(90,580.1)	189%
5	Цэвэр ашиг /алдагдал /	м/төг	(111,284.1)	(201,864.1)	(90,580.1)	189%
6	Нийт ажиллагсдын тоо	Хүн	14.0	14.0		
	Нийт цалингийн сан	м/төг	125,640.0	179,218.0	55,241.6	144.4%
	Нэг ажиллагчийн дундаж цалин	м/төг	747,8	1,066.0	328,0	111%
	Борлуулалтын орлогын 1 төг ногдох зардал	м/төг	0.74	0.85	(0.11)	

Дээрх хүснэгтээс харахад аудитад хамрагдсан сүүлийн 2 жилийн техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшний төлөвлөлтөд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

Борлуулалтын орлогыг өмнөх оноос 15 хувиар бууруулсан, Нийт зардлыг зах зээлийн үнийн өсөлт инфляц, 20 хувиар нэмэгдүүлэхээр тус тус төлөвлөсөн бөгөөд зардлын өсөлтийг ангиллаар нь авч үзэхэд ажиллагсдын цалингийн зардлыг 44,4 хувиар нэмэгдүүлж, борлуулалтын орлогын нэг төгрөгт ногдох зардлыг өмнөх оноос 0.11 буюу 11хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөж 2024 оны нийт орлогыг 315,060.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 426,346.0 мянган төгрөгөөр тогтоож 111,284.0 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн байна. 2025 оны нийт орлогыг 310,100.0 мянган төгрөгөөр, төлөвлөсөн нь тухай суманд спортын заалны барилга 2024 онд ашиглалтад орохоор

дулааны орлогыг 4,960.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэхээр төлөвлөгөө батлуулсан боловч барилга барьдаггүй учраас 2025оны дулааны борлуулалтын орлогын төлөвлөгөөг 15 хувиар бууруулсан . нийт зардлыг 511,964.1 мянган төгрөгөөр тогтоож 201,864.1 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн байна.

.Эрчим хүчний үр ашигтай үйлдвэрлэл явуулахын тулд нэгж тоноглолын ТЭЗҮ-г дээшлүүлэхэд чиглэсэн судалгаа шинжилгээг хийж техник технологид шаардагдах хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж тооцоогүй байна .

Авлагыг 2024-2025 онуудад 15,600.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн нь 2024 онд айл өрх, албан байгууллагын дулааны хэрэглээнд тавих хяналтыг хэрэгжүүлж талбайн хэмжилтийн зөрүүгээр үүссэн дулааны төлбөрийг барагдуулахаар нэмэгдүүлсэн байна

2.9. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшний гүйцэтгэл

Хүснэгт5

/мянган төгрөгөөр

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
			2024	2024		
1	Борлуулалтын орлого	м/төг	315,060.9	317,783.8	-2,722.9	100.9
2	Бусад орлого	м/төг			0.00	
3	Орон нутгийн татаас	м/төг		15,000.00	15,000.00	
4	Нийт орлого	м/төг	315,060.9	317,783.8	-2,722.9	100.9
5	Нийт зардал	м/төг	426,345.0	423,798.4	2,546.6	99.4
6	/Борлуулалтын өртөг	м/төг	365,829.5	362,282.6	-3,546.9	90.3
7	Удирдлагын зардал	м/төг	60,515.5	61,515.8	-1,000.3	101.7
8	Цэвэр ашиг /алдагдал /	м/төг	-111,284.1	-91,014.6	-20,269.5	81.8
9	Нийт ажиллагсдын тоо	Хүн	14	14		
10	Нийт цалингийн сан	м/төг	123,976.4	179,218.0	-55,241.6	145.0
11	Нэг ажиллагчийн дундаж цалин	м/төг	738,0	1,067.00	329,0	145.0
12	Борлуулалтын орлогын 1 төг ногдох зардал	м/төг	0.74	0.96	0.22	130.0

“

“Туулын Хишиг ” ОНӨААТҮГ 2024 онд дулааны орлого 309,692.5мянган төгрөгийн ,цэвэр усны орлого 8,091.3 мянган төгрөгийн нийт 317,783.8 мянган төгрөгийн орлогын бүрдүүлэлтийг төлөвлөгөөнөөс 2,722.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.Нийт орлогын 97,5 хувь дулааны үйлдвэрлэлийн орлого 2,5хувь цэвэр усны орлогын эзэлж байна.. Усны борлуулалтын орлого зардлаа өртгөө нөхөж чадахгүй төгрөгийн алдагдалтай байна

инженерийн шугамын дулаан ,ус цэвэр, бохир ус татан зайлуулах шугам сүлжээнд сүүлийн жилүүдэд их засварын ажлыг хийгээгүйгээс шугам гэмтэл ихтэйгээс шалтгаан цахилгаан

зардал 60,297.6 мянган төгрөг нүүрсний зардал 140,850.0 мянган төгрөгийн усны үйлчилгээний зардал 38,277.0 мянган төгрөгийн зардлууд нийт 239,424,6 мянган төгрөг болж үйлдвэрлэлийн нийт зардлын 56,4 хувь эзэлж байна .

Нийт зардлын гүйцэтгэл 423,798.4 мянган төгрөг болж төлөвлөснөөс 2,546.6 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь удирдлагын зардал 1,000.3 мянган төгрөгөөр цалингийн зардал 55,241.6 мянган төгрөгөөр, нийт 56,241,9 мянган төгрөгөөр хэтэрч, бусад зардал 58,788.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Дулааны сүлжээн дэх гидравликийн болон тооцоот температурын, дулааны алдагдлын байдлыг 3 жилд 1-ээс доошгүй удаа тусгайлсан туршилт хэмжилт хийж үр дүнг дулаан түгээлтийн төлөвлөлт болон сүлжээний гидравлик тооцоонд тусгаж байхаас гадна жил бүр шинээр баригдсан, өөрчлөгдсөн дулаан дамжуулах шугам сүлжээний алдагдлыг тооцоог нэмж байх инженерийн шугамын тооцоог хийж байх нь зүйтэй гэж үзэж байна.

Үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөг үндсэн үйл ажиллагааны үр дүнгээр алдагдалтай ажиллахаар төлөвлөж байгаа нь үйлдвэрийн газар өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар бие даан ажиллах чадваргүй нөхцөл байдалд хүргэж байна. Цаашид үйлдвэрлэлийн удирдлага, менежментийг сайжруулах замаар үйлдвэрлэлийн үр дүнгээр ашиг хүртэх нөхцөл боломж бий эсэх, шаардлагатай бол бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөлт хийх шаардлагатай байна

Хүснэгт 6

мянган төгрөгөөр

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
			2025	2025		
1	Борлуулалтын орлого	м/төг	155,055.4	177,088.0	22,032.7	114.0
2	Бусад орлого	м/төг				
3	Орон нутгийн татаас	м/төг				
4	Нийт орлого	м/төг	155,055.4	177,088.0	22,032.7	114.0
5	Нийт зардал	м/төг	255,982.0	247,153.0	-8,829.0	97.0
6	/Борлуулалтын өртөг	м/төг	218,904.0	189,245.0	29,659.0	86.0
7	Удирдлагын зардал	м/төг	37,078.0	57,908.0	20,830.00	156.0
8	Цэвэр ашиг /алдагдал /	м/төг	-100,927.0	-70,065.0	-30,862.00	69.0
9	Нийт ажиллагсдын тоо	Хүн	14	14		
10	Нийт цалингийн сан	м/төг	89,608.0	106,305.0	16,697.00	118.6
11	Нэг ажиллагчийн дундаж цалин	м/төг	1,067.00	1,265.5	198.5	118.6
12	Борлуулалтын орлогын 1 төг ногдох зардал	м/төг	0.60	0.72	0.12	102.0

2025 оны эхний хагас жилийн дулааны орлого 173,042.4 мянган төгрөгийн ,цэвэр

усны орлого 4,045.6 мянган төгрөгийн нийт 177,088,0 мянган төгрөгийн орлогын бүрдүүлэлтийг төлөвлөгөөнөөс 22,032.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 247,153.4 мянган төгрөг болж төлөвлөснөөс 8,829.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь удирдлагын зардал 20,830.0 мянган төгрөгөөр цалингийн зардал 16,697.0 мянган төгрөгөөр, нийт 77,071 мянган төгрөгөөр хэтэрч, бусад зардал 85,900,0 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна

Аудитын дүгнэлт, Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 258,363.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлснийг 65.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 7

/мянган төгрөгөөр/

Огноо	2024 он		Биелэлт		
	Хязгаарлалтай				
Аудитын дүгнэлт	Тоо	Дүн		Дүн	Хувь
Албан шаардлага	3	183,946.4	1	168,762.4	70
Зөвлөмж	3	74,416.8			100
Нийт дүн	6	258,363.2		168,762.4	65

1.

ГУРАВ. АУДИТЫН ҮР ДҮН

<u>Илэрсэн асуудал 1</u>	Тус үйлдвэрийн газрын дүрмийг шинэчлэн боловсруулж бүтэц зохион байгуулалт чиг үүргийг оновчтой тодорхой болгох замаар засаглалыг сайжруулах арга хэмжээг авахгүйгээр цаашид үргэлжлүүлэн, ашигтай ажиллаж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадахгүй нөхцөл байдалд хүрсэн байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал:	Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл, ажлын байрны чиг үүрэгт шинжилгээг хийж түүний үр дүнгээр байгууллагын дүрэмд бүтэц зохион байгуулалт, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоо, тайлагнал, мэдээллийн ил тод байдал, оролцогч талуудын эрх ашиг, байгууллагын соёл, албан тушаалын жагсаалт, орон тооны норматив, чиг үүргийг тодорхой болгох замаар шинэчлэн боловсруулж засаглалыг тогтолцоог сайжруулах шаардлагатай байна
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиргааны албан тушаалын жагсаалт, орон тооны нормативыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно, 77 дугаар үйлийн 77.1.4-д " Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах

шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих."

Асуудлын үндсэн шалтгаан:

Байгууллагын дотоод зохион байгуулалт, чиг үүргийн хуваарилалт, бүтэц, засаглалын тогтолцоог шинжилж, үнэлгээ хийж шинэчлэх үйл ажиллагааг орхигдуулсан. Үйлдвэрийн газрын дүрэмд шаардлагатай өөрчлөлт оруулаагүй, оролцогч талуудын эрх ашиг, дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, мэдээллийн ил тод байдлыг хангах зохицуулалт тусгагдаагүй байна.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Үйлдвэрийн газрын үр ашиг, санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж, өөрийгөө санхүүжүүлэх чадамж буурах эрсдэлтэй.

Ажлын байрны чиг үүрэг тодорхойгүйгээс хариуцлага, үр нөлөөний тогтолцоо сулрах, хүний нөөцийн оновчгүй хуваарилалт үүсэх.

Засаглалын ил тод, нээлттэй байдал алдагдаж, оролцогч талуудын итгэл буурах.

Шийдвэр:

Цаашид үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл, ажлын байрны чиг үүрэгт шинжилгээг хийж түүний үр дүнгээр байгууллагын дүрэмд бүтэц зохион байгуулалт, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоо, тайлагнал, мэдээллийн ил тод байдал, оролцогч талуудын эрх ашиг, байгууллагын соёл, албан тушаалын жагсаалт, орон тооны норматив, чиг үүргийг тодорхой болгох замаар дүрмийн шинэчлэлийн төслийг боловсруулж аймгийн Сумын даргад танилцуулж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэх арга хэмжээг авах **зөвлөмж** хүргүүлэх.

<u>Илэрсэн асуудал 2</u>	Орхонтуул сумын Засаг дарга нь 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр "Туулын Хишиг" ОНӨААТҮГ-ын даргатай гэрээ байгуулж 2024-2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, төлөвлөгөөг 111,284.1 мянган төгрөгийн алдагдалтай 2025 онд 201,864.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилахаар баталсан
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө дунд
Бодит байдал:	Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөхдөө учирч болох эрсдэлүүдийг авч бүртгэж түүнийг бууруулах талаар ярилцдаг боловч баримтжуулаагүй, үнэлгээ хийгдээгүй байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	MNS ISO 31010:2016 Эрсдэлийн үнэлгээний арга MNS ISO 31000:2020 Эрсдэлийн менежментийн удирдамж Эрсдэлийн удирдлагын журам, холбогдох заавар
Асуудлын үндсэн шалтгаан:	Эрсдэлийн удирдлагын тогтолцооны талаарх ойлголт, мэдлэг дутагдалтай Бодлого, журам, аргачлал батлагдаагүй Эрсдэлийн удирдлагыг байгууллагын төлөвлөлт, гүйцэтгэлийн процессод тусгаагүй
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах боломж алдагдана Үйл ажиллагаанд гэнэтийн доголдол, хохирол үүсэх эрсдэл өндөр Төлөвлөлт, шийдвэр гаргалтад мэдээлэл дутмаг, үндэслэл сул байх нөхцөл бүрдэнэ Тогтвортой, хариуцлагатай засаглал, менежментийн чадавх сулрах.
Шийдвэр:	Эрсдэлийн түвшингээр нь бага, дунд, их гэж ангилах замаар эрсдэлийн удирдлагын хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан эрсдэлийг удирдах нөхцөлийг бүрдүүлэн үр дүнг тооцож ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.
<u>Илэрсэн асуудал 3</u>	Гүйцэтгэх удирдлагын дотоод хяналтыг төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж ажиллаагүй байна
Асуудлын	Нөлөө дунд

ангилал	
Бодит байдал:	Байгууллагын удирдлагын дотоод хяналтыг төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх ажил зохион байгуулаагүй байна
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Үйлдвэрийн газрын дарга Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д " өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцах", ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.3-д Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна.
Асуудлын үндсэн шалтгаан:	Хяналт шалгалтын бодлого, журам боловсруулж баталгаажуулаагүй Төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх тогтолцоо бүрдээгүй
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Хууль, дүрэм, дотоод журмыг зөрчих эрсдэл нэмэгдэнэ Хэрэгжилтийн явц, гүйцэтгэлийн үнэн зөв байдал тодорхойгүй, ил тод бус байна Санхүү, хөрөнгө, хүний нөөцийн үр ашиггүй хэрэглээ, хариуцлагагүй байдал бий болох эрсдэл өндөр
Шийдвэр:	Цаашид дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, үр дүнг тайлагнах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

<u>Илэрсэн асуудал 4</u>	Засаг дарга нь 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр "Туулын Хишиг" ОНӨААТҮГ-ын даргатай гэрээ байгуулж 2024-2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, төлөвлөгөөг алдагдалтай ажилахаар баталсан
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал:	Орхонтуул сумын Засаг дарга нь 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр "Туулын Хишиг" ОНӨААТҮГ-ын даргатай гэрээ байгуулж 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, төлөвлөгөөг 91,014.6 мянган төгрөгийн алдагдалтай 2025 онд эхний хагас жилийн байдлаар 70,065.1 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж байна
Байх ёстой шаардлага /шалгуур	Засгийн газрын "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 2021 оны 388 дугаар тогтоолын 2.4 "төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, мөнгөн хөрөнгийн удирдлагыг дээшлүүлж, үр өгөөжийг өсгөх, төлбөрийн чадварын үзүүлэлтийг эрс нэмэгдүүлэх арга хэмжээ авах." заалттай нийцэхгүй "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
Асуудлын үндсэн шалтгаан:	Батлагдсан "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг дулаан хангамжийн системийн техник, технологи, санхүү, эдийн засаг, үр ашигтай байдал, зах зээлийн загвар, тогтолцоо, хүний нөөц, хөрөнгө оруулалтыг зэрэгт судлагаа шинжилгээ хийж бодит тооцоололгүй байна
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Тус байгууллагын техник, эдийн засгийн чадавхыг бэхжүүлж чадахгүй хүрнэ, дулаан хангамжийн, найдвартай байдлын үйл ажиллагаа сөрөг нөлөөлнө
Шийдвэр:	Цаашид дулаан хангамжийн тоо хэмжээ, чанар, үнэ, тариф, төлбөрийн журам, дулааны хэрэглээний горим, дулааны эх үүсгүүр, түүний тоног төхөөрөмж, дулааны сүлжээ, тэдгээрийг засварлах, шинэчлэх, сайжруулах, өргөтгөх, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулахад холбогдох хууль дүрэм, журамд, нийцсэн тодорхой бодит тооцоололтой үйлдвэрлэл санхүү төлөвлөгөөг боловсруулахыг зөвлөмж хүргүүлж байна

<u>Илэрсэн</u>	Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгө
-----------------------	---

асуудал 5	дахин ашиглах боломжгүй бүртгэлтэй байна.
Асуудлын ангилал	Нөлөө дунд
Бодит байдал: 260,651.0 мянган төгрөгийн 4 төрлийн хөрөнгө элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоолол хийхгээгүй байна	
Байх ёстой шаардлага /шалгуур/: үндсэн хөрөнгийн ангилалд бүртгэлтэй ашиглах боломжгүй, 260,651.0 мянган төгрөгийн 4 төрлийн хөрөнгө элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган аймгийн ОНӨГ-т хандаагүй	
Асуудлын үндсэн шалтгаан: хөрөнгө элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган аймгийн ОНӨГ-т хандаагүй	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Үндсэн хөрөнгийн ашиглалтад , санхүүгийн тайлангийн үнэн зөв байдалд сөргөөр нөлөөлнө	
Шийдвэр: Цаашид хөрөнгө элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоож гарган тухай жилд аймгийн ОНӨГ-т хандаж байхыг зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв	

Илэрсэн асуудал 6	2010 Оноос хойш Цэвэр усны бохир усны үнэ тариф өөрчилөлт хийгээгүй байна
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал 2010 Оноос хойш Цэвэр усны бохир усны үнэ тариф өөрчилөлт хийгээгүй байна.Усны борлуулалтын орлого , ус түгээж байгаа өртөг зардлаа нөхөж чадахгүй алдагдалтай ажиллаж байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Монгол Улсын хуулийн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9/ улсаас хатуу тогтоосноос бусад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох; 20.1.10/ эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах	
Асуудлын үндсэн шалтгаан: Цэвэр усны үнийн тарифт нэмэгдүүлэх техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтын судалгаа тооцлол хийж хэрэгжээгүй	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар . Байгууллагын үйл ажиллагаа хэвийн явуулахад үргүй зардал нэмэгдүүлж сөрөг үр дагавар бий болгоно.	
Шийдвэр: Цаашид цэвэр усны үнэ тарифт нэмэгдүүлэх, алдагдлыг бууруулж ажиллахыг зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.	

Илэрсэн асуудал 7	цэвэрлэх байгууламжийн технологи ажиллагаа байхгүйгээс сумын төвөөрөө бохир усны шугамаас гарсан хаягдал бохир ус ил урсаж байгаа хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учруулах хортой нөлөө,эрсдэлтэй байна
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал: цэвэрлэх байгууламжийн технологи ажиллагаа байхгүйгээс сумын төвөөрөө бохир усны шугамаас гарсан хаягдал бохир ус ил урсаж байгаа хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учруулах хортой нөлөө,эрсдэлтэй байна	

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Монгол Улсын хуулийн хот суурины ,ус хангамж,ариутгах татуургын ашиглалтын тухай хууль 8.1, 8.1.2.нутаг дэвсгэрийнхээ ус хангамж, ариутгах татуурга, гадаргын ус зайлуулах барилга байгууламжийг төлөвлөх талаар төсөл, хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах;

Асуудлын үндсэн шалтгаан: Сумын засаг дарга болон Иргэдийн хурлын төлөөлөгчдийн хуралд нөхцөл байдлыг таницуулж цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, **цэвэрлэх байгууламж нь барих санал** төсөл арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Сумын засаг дарга болон Иргэдийн хурлын таницуулж цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, **цэвэрлэх байгууламж нь барих санал** төсөл арга хэмжээ хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв

Шийдвэр:

Цаашид Сумын засаг дарга болон Иргэдийн хурлын төлөөлөгчдийн хурал таницуулж

Илэрсэн асуудал 8	2024 онд задгай хэрэглээний гэрээтэй Орхон сумын 7 аж ахуйн байгууллага 94айл өрхийн 246 иргэний бүртгэлтэй усны тоолуурыг суурилагагүйгээс орлого нэмэгдүүлэх боломжийг алдаж байна
Асуудлын ангилал	Нөлөө их

Бодит байдал: 2024 онд задгай хэрэглээний гэрээтэй Орхон сумын 7 аж ахуйн байгууллага 94айл өрхийн 246 иргэний бүртгэлтэй усны тоолуурыг суурилагагүйгээс орлого нэмэгдүүлэх боломжийг алдаж байна

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Барилга, Хот байгуулалтын сайдын 2018 оны 192 дугаар тушаалын хавсралт "Ус хангамж, ариутгах татуургын системийн техник ашиглалтын дүрэм"-ийн 2.11.2. Орон сууцны болон бусад хэрэглэгчдэд ундны цэвэр усыг зүй зохистой ашиглах нөхцөл бүрдүүлэхийн тулд ашиглалтын байгууллага, хэрэглэгчдийг усны хэмжүүр суурилуулахыг шаардах, хэрэглэгчдийн усны зарцуулалтад системтэйгээр хяналт тавих.

Асуудлын үндсэн шалтгаан:

Ашиглалтын байгууллага, хэрэглэгчдийг усны хэмжүүр суурилуулахыг шаардах, хэрэглэгчдийн усны зарцуулалтад системтэйгээр хяналт тавих.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Байгууллаганы ус орлого борлуулалт орлого дутуу бүрдүүлж байна

Шийдвэр:

Цаашид хэрэглэгчдийг усны хэмжүүр суурилуулаж ,цэвэр ус борлуулалтын орлого нэмэгдүүлж ажиллах **зөвлөмж** хүргүүлэхээр шийдвэрлэв.

Илэрсэн асуудал 9	цалин, нийгмийн даатгалын шимтгэл, удирдлагын зардлууд батлагдсан төлөвлөгөөнөөс хэтэрсэн нь байна
Асуудлын ангилал	Нөлөө их

Бодит байдал: Цалин зардлын гүйцэтгэл 179,218.0мянган төгрөг болж төлөвлөснөөс 55,241.6мянган төгрөгөөр гүйцэтгэл ,удирдлагын зардал 61,515.8 мянган төгрөгөөр,төлөвлөснөөс1,000,3 төгрөгөөр, нийт 56,241,9 мянган төгрөгөөр хэтэрсэн байна

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "үйлдвэрийн газрын

үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах; нийцсэн бөгөөд зохистой байх гэж заасныг хэрэгжүүлээгүй байна

Асуудлын үндсэн шалтгаан: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах хэрэгжилт хангагдаагүй байна.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөг үндсэн үйл ажиллагааны үр дүнгээр алдагдалтай ажиллахаар төлөвлөж байгаа нь үйлдвэрийн газар өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар бие даан ажиллах чадваргүй нөхцөл байдалд хүргэж байна

Шийдвэр:

Эрчим хүчний үр ашигтай үйлдвэрлэл явуулахын тулд нэгж тоноглолын ТЭЗҮ-г дээшлүүлэхэд чиглэсэн судалгаа, норм нормативыг боловсронгуй болгож, өртөг зардлыг тодорхой тооцож санхүүгийн тайланд дүн шинжилгээ алдагдлыг бууруулах ажлыг зохион байгуулж үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах ажиллахыг зөвлөмж хүргүүлэх шийдвэрлэв

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт **56,241.9** мянган төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Албан шаардлага:

- ✓ Сумын Засаг даргаар батлуулсан санхүүгийн төлөвлөгөөний цалингийн зардлыг 2024 онд Батлагдсан төлөвлөгөөнөөс цалингийн зардал 1,000.3 мянган төгрөгийн, Ерөнхий ба удирдлагын үйл ажиллагааны 55,241.6 мянган төгрөгийн нийт 56,241,9 зардлыг хэтрүүлсэн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ✓ Жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг зохицуулах, үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангах, ачаалал, халаалтын чанар, дулааны станцын хуучирсан насжилт өндөртэй үндсэн болон туслах тоноглолыг шинэчлэх ажлыг жил бүр үе шаттай хэрэгжүүлэхэд орон нутгийн удирдлагын зүгээс бодлогын түвшинд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад тусган шийдвэрлэж дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.
- ✓ Сумын ИТХ-ын зүгээс тус үйлдвэрийн газрын ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, алдагдлыг бууруулахад бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны дээд хязгаар, хариуцлагын тогтолцоог тус үйлдвэрийн газрын дүрэмд өөрчлөлт оруулах замаар шинэчлэн тогтоож гүйцэтгэх удирдлагын засаглалын менежментийг сайжруулахад хяналтын тогтолцоог бий болгох хэрэгцээ шаардлага үүссэн байна.

- ✓ оруулалтад тусган шийдвэрлэж дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.
- ✓ 2024 онд задгай хэрэглээний гэрээтэй Орхон сумын 7 аж ахуйн байгууллага 94айл өрхийн 246 иргэний бүртгэлтэй усны тоолуурыг суурилаагүйгээс орлого
- ✓ Байгууллагын хэмжээнд эрсдэлийг удирдлагын тогтолцоо төлөвшөөгүй эрсдэлийг бүртгэж үнэлэх дүгнэх, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх процесс хийгдэхгүй байна.
- ✓ Гүйцэтгэх удирдлагын дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжилүүлээгүй үр дүнг хангалтгүй байна.

Батлуулсан төлөвлөгөө биелэлтийг хангахгүй байна 2024 оны цалин зардлын 179,218.0мянган төгрөг болж төлөвлөснөөс 55,241.6мянган төгрөгөөр гүйцэтгэл удирдлагын зардал 61,515.8 мянган төгрөгөөр, төлөвлөснөөс 1,000,3 мянган төгрөгөөр, нийт 56,241,9 мянган төгрөгөөр хэтэрсэн байна. Батлуулсан төлөвлөгөө биелэлтийг хангахгүй байна

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Дотоод аудитаар танай байгууллагад “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дүгнэлтийн төрөл	Дүнгийн тайлбар
Сайжруулах шаардлагатай	Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь "давтамжтай буюу 1-р түвшин"-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 9-56% нь "нөлөө ихтэй" гэж үзсэн.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Туулын Хишиг ” ОНӨААТҮГ-ын дарга Х.Ганбат танд

- ✓ Цаашид үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл, ажлын байрны чиг үүрэгт шинжилгээг хийж түүний үр дүнгээр байгууллагын дүрэмд бүтэц зохион байгуулалт, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоо, тайлагнал, мэдээллийн ил тод байдал, оролцогч талуудын эрх ашиг, байгууллагын соёл, албан тушаалын жагсаалт, орон тооны норматив, чиг үүргийг тодорхой болгох замаар дүрмийн шинэчлэлийн төслийг боловсруулж аймгийн Сумын даргад танилцуулж сумын ИТХ-аар хэлэлцүүлэх арга хэмжээг
- ✓ Эрсдэлийн түвшингээр нь бага, дунд, их гэж ангилах замаар эрсдэлийн удирдлагын хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан эрсдэлийг удирдах нөхцөлийг бүрдүүлэн үр дүнг тооцож ажиллах
- ✓ Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, үр дүнг тайлагнах
- ✓ Дулаан хангамжийн тоо хэмжээ, чанар, үнэ, тариф, төлбөрийн журам, дулааны хэрэглээний горим, дулааны эх үүсвүүр, түүний тоног төхөөрөмж, дулааны сүлжээ, тэдгээрийг засварлах, шинэчлэх, сайжруулах, өргөтгөх, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулахад , холбогдох хууль дүрэм, журамд,

нийцсэн тодорхой бодит тооцоололтой үйлдвэрлэл санхүү төлөвлөгөөг боловсруулахыг

- ✓ Сумын ерөнхий төлөвлөгөөний, инженерийн дэд бүтцийн төлөвлөгөөнд оруулж бохир цэвэрлэх барилга байгууламжийн зураг төсөв, цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, **цэвэрлэх байгууламж нь барих санал** боловсруулж инженерийн техник тоноглолыг шинэчлэлтийг тусган төлөвлөж, хэрэгжүүлэх санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад тусган шийдвэрлэж дэмжлэг үзүүлэх шаардлагатайг сумын Засаг даргад танилцуулж сумын ИТХ-аар хэлэлцүүлэх арга хэмжээг авах
- ✓ Хөрөнгө элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцож гарган тухай жилд аймгийн ОНӨГ-т хандаж байх
- ✓ Хэрэглэгчдийг усны хэмжүүр суурилуулаж ,цэвэр ус борлуулалтын орлого нэмэгдүүлэж ажиллах
- ✓ Цэвэр усны үнэ тарифт нэмэгдүүлэх, алдагдлыг бууруулж ажиллах
- ✓ Хэрэглэгчдийг усны хэмжүүр суурилуулаж ,цэвэр ус борлуулалтын орлого нэмэгдүүлэж ажиллах
- ✓ Эрчим хүчний үр ашигтай үйлдвэрлэл явуулахын тулд нэгж тоноглолын ТЭЗҮ-г дээшлүүлэхэд чиглэсэн судалгаа, норм нормативыг боловсронгуй болгож, өртөг зардлыг тодорхой тооцож санхүүгийн тайланд дүн шинжилгээ алдагдлыг бууруулах ажлыг зохион байгуулж үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах ажиллахыг зөвлөмж хүргүүлэх шийдвэрлэв

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:
ДОТООД АУДИТОР

Д.ВАНЧИГМАА

ТАЙЛАН ХЯНАСАН:
АХЛАХ СХШУАБ



Т.МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН:
"ТУУЛЫН ХИШИГ" ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА

Х.ГАНБАТ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

П.СОЛЬ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 47/
32-02

Сүхбаатар сум

Зөрчил арилгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн ДА-2025/03/ҮА-ОНА дугаартай удирдамжийн дагуу Туулын Хишиг ОНӨААТҮГ-ын 2024он 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар сумын Засаг даргаар батлуулсан санхүүгийн төлөвлөгөөний цалингийн зардлыг 2024 онд 1,000,300.0 (Нэгэн сая гурван зуун төгрөг)-өөр, Ерөнхий ба удирдлагын үйл ажиллагааны зардлыг .55,241,600.0 (Тавин таван сая хоёр зуун дөчин нэгэн мянган зургаан зуун төгрөг)-өөр, нийт 56,241,900.0 (Тавин зургаан сая хоёр зуун дөчин нэгэн мянган есөн зуун төгрөг)-өөр хэтрүүлэн зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.Захирал дараах эрх, үүрэгтэй: 20.1.3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ." гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аймгийн Засаг даргаар батлуулсан санхүүгийн төлөвлөгөөний дагуу зардлын ангиллыг хэтрүүлэхгүй байх.
2. Цаашид дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 11 дугаар сарын 05-ны өдрийн дотор Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлэхийг Туулын Хишиг ОНӨААТҮГ-ын дарга Х.Ганбат, Ерөнхий нягтлан бодогч Р.Соль нарт даалгав.

4325007129

3. Улсын ахлах байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.
4. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
ГАЗРЫН САНХҮҮ ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ
БАЙЦААГЧ



Т.МӨНХЗУЛ

ЗӨВШӨӨРСӨН:

ТУУЛЫН ХИШИГ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА *Х.ГАНБАТ* Х.ГАНБАТ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ



П.СОЛЬ